



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/87

Хатан суудал

Малжуулах арга хэмжээг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Баянхонгор аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” 485 дугаар тоот албан бичиг, Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг арга хэмжээ” 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг арга хэмжээ”-д хамрагдах хүсэлтэй малчин өрхийг сонгон шалгаруулж, материалыг бүрдүүлж Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргүүлэх.

2. Малчин өрхийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Амарбаяр (Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Оюунтунгалаг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Н.Цэрэндолгор (Хөдөө аж ахуй тасгийн дарга)

3. Малжуулах хөтөлбөрт хамрагдах өрхийг сонгон шалгаруулж, тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд хяналт тавьж тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Амарбаяр)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ

642301141